



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Шим ус” ОНӨХХК-ны 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/015/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Д.Нямгарав Утас: 70432545 Цахим хаяг: nyamgaravd@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
3.1 Зөвлөмж	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.15 № 249
танай _____ -ны № _____ -т

“ШИМ УС” ОНӨХХК-НЫ
ЗАХИРАЛ Я.ГАНЗОРИГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шим ус” ОНӨХХК-ны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.3, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.6, 15.2.7, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.6, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4, Нийтийн албанд нийгмийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 11 дүгээр зүйлийн 11.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4-д заасан заалттай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- 2025 онд нийт ажилтнуудад олгосон үр дүн, ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүйгээр 110,901.1 мянган төгрөгийг олгосон;
- Хувь хүний орлогын албан татварын тайланд цалин хөлс түүнтэй адилтгах орлогод 2025 оны 11 дүгээр сард ажилчдад олгосон гэрээт цалингаас суутгасан 9,294.1 мянган төгрөгийг дутуу тусгасан;

- Тус байгууллагад шатахуун тослох материалын норм нормативыг тогтоосон тушаал шийдвэргүйн улмаас шатахууны тооцоог 5,314.4 мянган төгрөгөөр илүү, дутуу тайлагнасан;
- Тухайн байгууллагын өөрийн хөрөнгөөр портер авто машин 22,600.0 мянган төгрөг, программ хангамж 37,432.5 мянган төгрөгөөр худалдан авч данс бүртгэлд тусгасан боловч мөнгөн гүйлгээний тайлангийн дотоод эх үүсвэрээр үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн гэдэг дансанд бүртгээгүйгээс тайлант үеийн үр дүнг бууруулсан;
- Тус байгууллагын хуулийн зөвлөхөд 7,920.0 мянган төгрөгийн цалингаас 2,708.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган төлсөн боловч авлагаар тусгаагүй;
- Албан томилолтын зардлыг хувь хүний харилцах данс руу шилжүүлэхийг зогсоохоор зөвлөмж өгөгдсөн ч зөрчил арилгуулаагүй 7,110.0 мянган төгрөг,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын төсвөөр тэмцээн зохион байгуулах зардалд 13,152.6 мянган төгрөгийг зарцуулж, үрэлгэн зарцуулалт гаргасан,
- Нэмэгдсэн өртгийн албан татвараар 2025 оны нийт худалдан авалт, борлуулалтын тооцоог буруу тайлагнасан;
- Нийтийн албанд нийгмийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Ховд аймгийн "Шим-Ус" ОНӨХХК-ны хариуцдаг айл өрх, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 62 тоот тогтоолын дагуу төсөвт байгууллагаас бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхийн батлагдсан тарифыг 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс, төсөвт байгууллагын батлагдсан тарифыг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр тус тус шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Шим ус” ОНӨХХК нь 2025 онд 1,426.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, аймгийн орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 783.0 сая төгрөгийн өртөгтэй 9 ажил хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд нийт 5,517.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,919.1 сая төгрөгийг зардалд зарцуулсан, 73.6 сая төгрөгийн үйл ажиллагааны ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.ХӨРӨНГӨ		
1.1.Эргэлтийн хөрөнгө		
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	130,348,311.57	466,890,539.47
1.1.2. Дансны авлага	278,492,331.64	660,136,165.65
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	16,916,417.33	5,680,770.62
1.1.4. Бусад авлага	30,000.00	-
1.1.5.Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6.Бараа материал	2,550,037,589.14	2,652,896,952.64
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	2,976,024,649.68	3,873,376,169.00
1.2. Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1 Үндсэн хөрөнгө	29,520,844,343.29	27,785,274,743.41
1.2.2 Биет бус хөрөнгө	5,745,000.04	23,629,772.80
1.2.8 Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	29,526,589,343.33	27,808,904,516.21
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	32,502,613,993.01	31,682,280,685.21
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
2.1.1 Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1 Дансны өглөг	17,802.11	-
2.1.1.3 Татварын өр		6,967,131.40
2.1.1.4 НДШ-ийн өр	131,839.97	-
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	1,251,528,601	-
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,251,678,243.08	6,967,131.40
2.2 Өр төлбөрийн нийт дүн	1,251,678,243.08	6,967,131.40
2.3 Эздийн өмч		
2.3.1 Төрийн	10,086,961,840.33	10,086,961,840.33
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	697,760,587.00	697,760,587.00
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	22,488,059,886.82	22,838,785,908.10
2.3.9 Хуримтлагдсан ашиг	-2,021,846,564.22	-1,948,194,781.62
2.3.11 Эздийн өмчийн дүн	31,250,935,749.93	31,675,313,553.81
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	32,502,613,993.01	31,682,280,685.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	3,791,163,353.38	5,517,178,442.56
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,304,345,697.88	4,313,362,763.84
3. Нийт ашиг (алдагдал)	486,817,655.50	1,203,815,678.72
4. Ерөнхий ба удирдлагын зардал	962,481,113.78	1,122,363,790.31
4.1. Зардлын дүн	962,481,113.78	1,122,363,790.31
6. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-126,648,503.42	
7. Олз, гарзын дүн	-126,648,503.42	
8. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-602,311,961.70	81,835,314.00
9. Орлогын татварын зардал	3,222,043.34	8,183,531.40
10. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-605,534,005.04	73,651,782.60
15. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)		

16. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-605,534,005.04	73,651,782.60
--	------------------------	----------------------

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	10,086,961,840.3	697,760,587.0	17,431,634,837.8	-1,246,818,532.1	26,969,538,732.9
2	НБББ өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	5,056,425,049.0	-169,494,027.0	4,886,931,022.0
3	Залруулсан үлдэгдэл					-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-605,534,005.0	-605,534,005.0
1	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	10,086,961,840.3	697,760,587.0	22,488,059,886.8	-2,021,846,564.2	31,250,935,749.9
2	НБББ өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			350,726,021.2	(169,494,027.0)	350,726,021.2
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				73,651,782.6	73,651,782.6
9	2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	10,086,961,840.3	697,760,587.0	22,838,785,908.1	-1,948,194,781.6	31,675,313,553.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1 Мөнгөн орлогын дүн	4,401,025,919.89	6,274,711,496.19
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,378,576,997.09	5,835,738,407.36
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	22,448,922.80	438,973,088.83
1.2 Мөнгөн зарлагын дүн	4,302,272,243.48	5,874,680,268.29
Ажиллагчдад төлсөн	1,446,090,649.37	2,192,355,292.98
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	411,709,535.33	643,972,380.06
Бараа материал худалдан авахад төлсөн	926,943,564.00	1,327,975,081.00
Ашиглалтын зардал төлсөн	718,994,235.49	629,885,134.11
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	237,219,044.00	274,938,565.00
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	429,269,915.29	625,944,969.54
Даатгалын төлбөрт төлсөн	7,200,000.00	8,000,000.00
Бусад мөнгөн зарлага	124,845,300.00	171,608,845.60
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	98,753,676.41	400,031,227.90
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгөн зарлагын дүн		63,489,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		63,489,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		

2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		-63,489,000.0
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	98,753,676.41	336,542,227.90
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,594,635.16	130,348,311.57
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	130,348,311.57	466,890,539.47

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл (төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он Төлөвлөгөө	2025 он Гүйцэтгэл	Зөрүү +,-
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	мян,төг	5,565,838.9	5,517,561.8	-48,277.1
1.1	Үндсэн үйл ажиллагааны бус банкны хүүгийн орлого	мян,төг		383.4	383.4
2	Нийт зардал	мян,төг	5,559,717.3	5,443,910.0	-115,807.3
3	Үйл ажиллагааны ашиг, алдагдал	мян,төг		81,835.3	81,835.3
4	Татвар - ААНБОА	мян,төг		8,183.5	8,183.5
5	Татварын дараах ашиг, алдагдал	мян,төг	6,121.6	73,651.7	67,530.1
6	Тусгай зөвшөөрөл хүсэх үйл ажиллагааны - Цэвэр, бохир усаар	мян,төг	19,5	19,8	-0,3
6.1	Орлого	мян,төг	5,565,838.9	5,517,178.4	-48,660,5
6.2	Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны орлого	мян,төг	4,513,214.1	4,711,440.6	198,226,5
6.3	Бусад орлого	мян,төг	1,052,624.7	805,734.8	-246,889.9
6.4	Зардал	мян,төг	5,559,717.3	5,443,910.0	-115,807.3
6.5	Ашиг алдагдал	мян,төг	6,121.6	73,651.7	67,530.1
10	Нийт ажиллагсад	тоо	118	104	-14
10.1	Цалингийн сан	мян,төг	2,313,440.4	2,291,351.1	22,089.3
10.2	Дундаж цалин	мян,төг	1,633,7	1,836.0	202.3

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 162,100.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,619.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Тухайн байгууллагын өөрийн хөрөнгөөр портер авто машин 22,600.0 мянган төгрөг, программ хангамж 37,432.5 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч данс бүртгэлд тусгасан боловч мөнгөн гүйлгээний тайлангийн дотоод эх үүсвэрээр үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн гэдэг дансанд бүртгээгүйгээс тайлант үеийн үр дүнг бууруулсан.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий

¹ Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 148,840.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын 66,590.6 мянган төгрөгийн түвшнээс “их” байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 148,840.9 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, зөрчлийг таслан давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Цалин томилолттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд нийт ажилчдадаа ур чадварын нэмэгдэл 110,901.1 мянган төгрөгийг тушаал шийдвэргүйгээр хавтгайруулан олгосон, албан томилолтын мөнгийг хувийн харилцах дансруу 7,110.0 мянган төгрөгийг нэг хийж холбогдох баримт дутуу бүрдүүлсэн зэрэг нийт 118,011.1 мянган төгрөгийг зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн албаны тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.2-т “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, түүний хэмжээг Засгийн газар тогтооно”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4-д “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 тоот тушаалын холбогдох заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн нэмэгдлийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тухай бүр тооцон олгох, албан томилолтын хуудсаар сургалтанд хамрагдах шийдвэр бүхий албан тоотонд заасан хоногоор томилолтыг олгож хэвших.

3.1.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2025 онд тус байгууллага нь 13,152.6 мянган төгрөгөөр тэмцээн уралдаан зохион байгуулсан, хуулийн зөвлөх ажиллуулсан, мөн шатахуун тослох материалын норм нормативыг тогтоосон тушаал шийдэргүйн улмаас шатахууны тооцоо 5,314.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 5 дугаар зүйлийн 5.3-д “Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно.”, 15 дугаар зүйлийн 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”, 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох”, 15.2.7-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт

зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн байгууллагын төсвөөр тэмцээн уралдаан зохион байгуулахыг таслан зогсоож, хуулийн зөвлөх буюу хуулийн зөвлөхтэй ижил нэршилтэй, ижил ажил үүрэг гүйцэтгэх албан тушаалтныг ажиллуулахгүй байх, авто машины шатахуун тооцох норм нормативыг тогтоосон эрх зүйн шийдвэр гаргуулж, санхүүгийн анхан шатны иж бүрэн баримт бүрдлээр төсвийг зарцуулах.

3.1.3 Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын хуулийн зөвлөхөд олгосон 7,920.0 мянган төгрөгийн цалингаас 2,708.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган төлсөн боловч авлагаар тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу суутган тооцож, нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлэн нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах.

3.1.4 Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хувь хүний орлогын албан татварын тайланд цалин хөлс түүнтэй адилтгах орлогод 2025 оны 11 дүгээр сард ажилчдад олгосон 105,013.3 мянган төгрөгийн цалингаас 9,194.1 мянган төгрөгийг тайлагнаагүй орхигдуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүний орлогын албан татварыг хуулийн дагуу суутгасан татварыг татварын байгууллагад төлж, татварын байгууллагатай тооцоо нийлэх.

3.1.5 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Улсын онцгой комиссоос бохир ус тээвэрлэх, зөөвөрлөх авто машины үнийг орлогод аваагүй /өмнөх завсрын аудитаар зөвлөмж өгсөн/, мөн тус байгууллагын Пургон авто машин дотоод цэргийн албанд шилжүүлнэ гээд шийдвэр гараагүй байхад авто гражинд байгаагүй /тайлбартай/ зэрэг нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг зөрчиж,

санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагын шийдвэрээр автомашинуудыг данс бүртгэлд тусгах.

3.1.6 Бүтэц, орон тоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тухайн байгууллагын тооцооны нягтлан бодогч нь байгууллагын удирдлагатай хамаарал бүхий этгээд мөн учраас "Нийтийн албанд нийгмийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "хамаарал бүхий этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр/нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг", 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: "Нийтийн албанд нийгмийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийг мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллах.

3.1.7 Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуудал

Илрүүлэлт: тус байгууллагын 2025 оны нийт худалдан авалт, борлуулалтаас тооцсон НӨАТ зөрүүтэй тайлагнасан нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4, 7 дугаар зүйлийн 7.1.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ”, 8 дугаар зүйлийн 8.1.1-д “бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд” гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татварыг борлуулалт, худалдан авалт нэг бүрт татвар ногдуулж, татварын байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулан тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Шим ус ОНӨХХК	Тухайн байгууллагын өөрийн хөрөнгөөр портер авто машин 22,600,000 төгрөг, программ хангамж 37,432,545 төгрөгийг хөрөнгийн зардалд дутуу бүртгэж тайлант үеийн үр дүнг бууруулсан	1	13,619.4			1	13,619.4	1	13,619.4				
ДҮН		1	13,619.4			1	13,619.4	1	13,619.4				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Шим-Ус ОНӨХХК	Тайлант хугацаанд ур чадварын нэмэгдэл 110,901.1 мянган төгрөгийг тушаал шийдвэргүйгээр хавтгайруулан олгосон, томилолтын зардлыг ажилтны хувийн харилцах руу шилжүүлдэг	1	118,011.1						1	118,011.1		
	Байгууллагын төсвөөр тэмцээн уралдаан зохион байгуулсан, хуулийн зөвлөх ажиллуулсан, шатахуун тослох материалын норм нормативыг тогтоосон тушаал шийдэргүйн улмаас шатахууны тооцоог зөрүүтэй тайлагнасан	1	18,467.0						1	18,467.0		
	Тус байгууллагын хуулийн зөвлөхөд олгосон 7,920.0 мянган төгрөгийн цалингаас 2,708.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутган төлсөн боловч авлагаар тусгаагүй	1	2,708.6						1	2,708.6		

**“Шим-Ус” ОНӨХХК-ны 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан**

Хувь хүний орлогын албан татварын тайланд цалин хөлс түүнтэй адилтгах орлогод 2025 оны 11 дүгээр сард ажилчдад олгосон цалингаас 9,294.1 мянган төгрөгийг тайлагнаагүй орхигдуулсан	1	9,294.1					1	9,294.1		
Улсын онцгой комиссоос бохир ус тээвэрлэх, зөөвөрлөх авто машины үнийг орлогод аваагүй, дотоодын цэрэгт байгууллагын Пургон авто машиныг шилжүлэх гараагүй байхад гражинд байгаагүй	1						1	-		
Тухайн байгууллагын тооцооны нягтлан бодогч нь захиралтай хамаарал бүхий этгээд бөгөөд Нийтийн албанд нийгмийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй	1	-					1	-		
Тус байгууллагын 2025 оны нийт худалдан авалт, борлуулалтаас тооцсон НӨАТ зөрүүтэй тайлагнасан	1	-					1	-		
ДҮН	7	148,480.9					7	148,480.9		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨҮГ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		